

Олон улсын харилцааны ахисан түвшний судалгааны онол-аргазүйн зарим асуудал

Д.Уламбаяр¹

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд олон улсын харилцааны ахисан түвшний судалгаа гэж юуг хэлэх вэ, үүнд улс төрийн шинжлэх ухааны үндсэн категориуд аргазүйн ямар ач холбогдолтой тухайд өгүүлэх болно.

Түлхүүр үг: Ахисан түвшний судалгаа, олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухаан, категори, тусгай, ерөнхий ба онцгой, тоо ба чанар, агуулга ба хэлбэр, мөн чанар ба үзэгдэл, шалтгаан ба үр дагавар, зайлшгүй ба санамсаргүй.

Abstracts: The categories of political science has most important in advanced international studies. This article talks about a key issues in advanced international studies and their methodological perspectives.

Keywords: Advanced studies, international relations, political science, category, special, generally and specially, quantitative and qualitative, contents and forms, essence and visible, casus foederis and consequently, inevitably and unintentionally, possibility and reality, etc.

* * *

¹ Д. Уламбаяр. Доктор, профессор, ХИС-ийн Олон улсын харилцаа, Нийгэм судлалын сургуулийн захирал

1. Удиртгал

Гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөгдөж буй үйл явцтай уялдан шийдвэр гаргах бүх түвшинд мэдлэг, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээнд тулгуурлахын ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдсээр байна. Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов. Тиймээс *олон улсын харилцааны глобал болон бүс нутгийн геополитикийн орчинд тогтвортой, урьдчилан таамаглаж болохуйц байдлыг хадгалах явдал нэн чухал байна. Нөгөө талд дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан олон мянган жилийн явцтай хувьсал өөрчлөлтүүд хэдхэн арван жилийн дотор болж байгаа явдал юм.* Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байх гэдэг нь даяаршлын үед харьцангуй ойлголт бөгөөд тэгэх тусмаа дангаараа бүрэн хангах боломжгүй юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдээж байх учиртай ажгуу.

Эдүгээ нэгд, улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, хоёрт, гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах, гуравт, олон улсын харилцаа, геополитикийн орчны өөрчлөгдөн буй бодит байдалд судалгаа, дүн шинжилгээтэй хандах болон дотоод, гадаад улс төр, эдийн засгийн бодлогын нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, шийдвэр гаргах шинжлэх ухааны үндэслэлийг боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдал, дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр нөлөө, зах зээлийн конъюнктур, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, шинэ өвчний цар

тахал, уламжлалт бус аюул зэрэг геополитикийн гадаад орчин, төсөв, мөнгө, хөрөнгө оруулалтын бодлого, ардчилал, засаглалын чанар зэрэг геополитикийн дотоод орчны мэдэгдэхүйц хувьсал улс орны удирдлагыг богино хугацаанд оновчтой, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв шийдвэр гаргах, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (*preventive diplomacy*), хямралын менежментийг (*crisis management*) шуурхай хэрэгжүүлэхийг шаардах болов.

Хүйтэн дайн дууссанаар Монголын геополитикийн орчин үндсээрээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (*land-locked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (*nuclear-locked*), хоёр их гүрний дунд хашигдсан (*power-locked*), мөн монгол угсаатнаар хүрээлэгдсэн (*mongols ethno-locked*) сул бүрхүүлтэй цоо шинэ нөхцөл байдал буй болов. Геополитикийн шинэ орчинд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, бие даасан, нээлттэй гадаад бодлого явуулах болсон нь ХХ зууны сүүлчийн улиралд Монгол Улсын гадаад харилцаанд гарсан хамгийн том ололт мөн.

Монгол Улс дэлхийд хамгийн том газар нутагтай, мөн хамгийн олон хүн амтай, мөн өөр өөрийн онцлог байр суурьтай хоёр гүрний дунд оршдог, үүгээрээ цорын ганц гэж хэлж болохоор, түүнчлэн далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, хөгжлийн тусламж горилогч, буурай хөгжилтэй орон байсан бол эдүгээ хоёр *аварга зааны дунд жороолж буй galloper* буюу *чандаст хөлөг* гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, геоэдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна. *Монгол Улсыг хоёр гүрний хооронд хавчуулагдсан sandwich, бага жижиг улс, дэлхийн зах зээлээс алслагдсан, хөгжлийн тусламж горилогч гэх мэтээр нэрлэж байсан геополитикийн томъёолол үндсэндээ хуучрав.*

1. Ахисан түвшний судалгааны зорилго, мөн чанар

Энэхүү илтгэл: **Нэгд:** ахисан түвшний судалгаа гэж ямар судалгааг хэлэх вэ? (олон улсын харилцааны ахисан түвшний судалгаа гэж юуг хэлэх вэ)

Хоёрт: түүний судалгааны онол-аргазүйн гол бүрдвэл болсон улс төрийн шинжлэх ухааны категориуд гэж юуг хэлэх вэ?

Гуравт: дээрхийг БРИКС болон E7-гийн загвараар тайлбарлах

Дөрөвт: Судалгааны макро түвшин ба олон улсын харилцаа хийгээд Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм гэсэн хэсгүүдээс бүрдэж байгаа юм.

Жонс Хопкинс Их сургуулийн Пол Нитцийн нэрэмжит Олон улс судлалын ахисан түвшний сургууль (Paul Y.Nitze School of Advanced International Studies), Жоржтауны Их сургуулийн Эдмунд Уольшийн нэрэмжит Гадаад Албаны сургууль, (Edmund A.Walsh School of Foreign Service, Georgetown University), Нидерландын Олон улсын харилцаа, дипломатын академи «Clingendeal» (Netherlands Academy of International Relations and Diplomacy «Clingendeal»), Австрийн Венийн Дипломатын академийн (Diplomatische Academy Wien) ахисан түвшний технологи болон судалгаанд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Америкийн үндэстэн дамнасан олон улсын consulting, хөрөнгө оруулалтын “Goldman Sachs Group”, PricewaterhouseCoopers корпорацийн ахисан түвшний судалгаа онцгой анхаарал татдаг.

Ахисан түвшний судалгаа гэдэг нь: Судалгааны сэдэвт төсөл зангилаа (hub), тулгамдсан (key), хүртээмжтэй байх шинж (inclusive), төлөвлөгөө нарийвчлагдсан байх (blueprint), судалгааны өгөгдөл (data), параметрийг зөв тогтоох, анхдагч эх сурвалжтай ажиллах, олон улсын индекстэй сэтгүүлээс иш татсан байх (thomson reuters index), зөрчилдөөнийг илрүүлэн тогтоож, мөн чанарыг тодорхойлох, эндээс ерөнхий ба харьцангуй зүй тогтолыг (general and relativity regularity (law)) нээн илрүүлж, танин мэдэх (gnoseology), үзэгдлүүдийн түгээмэл холбоог гаргах, хуримтлагдсан шинжлэх ухааны мэдлэгийг

(epistemology) зөв удирдан залах (manipulation), хуваарилах үндсэн дээр шинэ мэдлэг буй болгох, тийнхүү **мэдлэгийн хүрсэн түвшинг урагшлуулж, инновацийн чадавхийг бий болгох**, шийдлийн боломжит хувилбаруудыг санал болгох, нийтлэг загварчлал гаргах, эрсдлийн үнэлгээ хийх, үр дүн нэмэгдсэн өртөгтэй (value added) байх явдалд оршино. Судалгааны дүнд гарсан урьдчилсан дүгнэлтүүд бодит байдал, үйл явцаар нотлогдохуйц байх ёстой ажгуу.

Олон улсын харилцааны ерөнхий (мөн харьцангуй) зүй тогтол гэдэг нь олон улсын харилцаанд зайлшгүй үүсэн бий болж, хувьсаж, хөгжиж буй үйл явцын гол чухал юмс, үзэгдэл, харилцан хамаарал, түүний мөн чанар, агуулга, хэлбэр тодорхой үе шатанд давтагдаж байдаг тэрхүү шинжийг хэлнэ. Олон улсын харилцааны үйл явц, юмс, үзэгдэл, ерөнхий ба харьцангуй шинж чанартай байдаг. Бид гагцхүү тэрхүү зүй тогтолт шинж шинж чанарыг танин мэдэх явдал нэн чухал болой.

Ахисан түвшний судалгааны үндсэн зарчим нь нэгд, шинжилгээ бодитой байх (объектив чанартай байх) зарчим; хоёрт, түгээмэл гинжин холбоог хангах (supply chain connectivity) зарчим, хөгжил түгээмэл гинжин шинжтэйн зарчим (chain development) эдгээр болно.

Судалгааг мэргэжсэн хамтлаг буюу *think-tank* гардан явуулдаг агаад мөн ч магистрант, докторантуудыг судалгаанд өргөнөөр татан оролцуулдаг.

II. Ахисан түвшний судалгаанд улс төрийн шинжлэх ухааны категориудын харгалзахын чухал болох нь

Олон улсын харилцаа бол улс төрийн шинжлэх ухааны салбарт хамаарагддаг нэг үндсэн чиглэл мөн билээ. Олон улсын харилцааны ахисан түвший судалгааны аргазүй нь улс төрийн шинжлэх ухааны категориудад тулгуурлана. Категори (category) буюу (ай) нь үнэн байдал болон олон улсын харилцааны танин мэдэхүйн үзэгдэл, юмсын хамгийн ерөнхий, хамгийн гол шинж, тал, харилцааг тусгасан үндсэн ойлголтыг илэрхийлнэ. Энэ нь асуудлыг системчлэн ерөнхийгөөс тусгайд, тусгайгаас ерөнхийд шилжих замаар мөн чанарыг илрүүлэн

дүгнэлт гаргахад нэн чухал. Дараах категориудыг дурдаж болно. Үүнд:

1. Тусгай, Ерөнхий ба Онцгой (Special, Generally and Specially)
2. Тоо ба чанар (Quantitative and Qualitative)
3. Агуулга ба хэлбэр (Contents and Forms)
4. Мөн чанар ба үзэгдэл (Essence and Visible)
5. Шалтгаан ба үр дагавар (Causa foederis and Consequently)
6. Зайлшгүй ба санамсаргүй (Inevitably and Unintentionally)
7. Боллоцоо ба бодит байдал (Possibility and Reality) эдгээр болно.

Тусгай хэмээх категори бол харьцангуй бие даасан шинжийг эзэмшсэн бөгөөд орон зай, цаг хугацааны дотор бусад юмс үзэгдэл буюу системээс хязгаарлагдсан, өөрийнхөө бүтэц, үүргээрээ бүхлийг бүтээж буй тодорхой нэг юмс буюу юмсын системийг тэмдэглэдэг. Тусгай юмс болгон ерөнхийд багтах шинж, тэмдэгтэйн дээр өөрийн өвөрмөц (онцгой), хувийн шинж тэмдэгтэй байдаг учраас ерөнхийгөөс баялаг ажгуу.

Объектив шинжтэй түгээмэл тал, шинж харилцаа нь *ерөнхий* хэмээх категорид тусгалаа олдог. Ерөнхий нь тусгай гол тал, мөн чанар нь болдог учраас тусгайгаас гүн гүнзгий байдаг ажээ. Ерөнхий, тусгайн категори хоорондоо салшгүй холбоотой. Олон улсын харилцааны аливаа юмст үзэгдэлд ерөнхий, тусгай аль аль нь байдаг. Үүний хамтаар юмс үзэгдэл *онцгой* буюу *singularity* байдаг.

Онцгой хэмээх категори бол ерөнхий, тусгайн хоорондын завсрын холбоос байж болно. Энэ бол онцгой нь өөрөө тусгайд харьцуулахад ерөнхий, илүү ерөнхийд харьцуулбал бага зэрэг ерөнхий болон илэрч байдаг харьцангуй зүйл мөн гэсэн үг болой. Онцгой категори бол тусгай, үзэгдэлд түгээмэл зүй тогтол илрэх хэлбэр, янз бүрийн талыг тусгадаг. Тэдгээр янз бүрийн тал, илрэх хэлбэр нь тухайн үзэгдлийн өвөрмөц онцлогоор тодорхойлогдоно. Тусгайд ерөнхий илрэх онцлогийг тодорхойлдог түгээмэл зүй тогтлыг танин мэдэх нь практик үйл ажиллагаанд асар их ач холбогдолтой.

Чанар бол олон улсын харилцааны аливаа нэг юмс, үзэгдэл нөгөөгөөсөө зааглагдаж байгаа ялгаа, тэдгээрийн мөн чанар, өвөрмөц онцлогийг илэрхийлсэн шинж тэмдгийн нийлбэр цогц, тухайн юмс үзэгдлийн дотоод тогтолцоо юм. Юмсын *чанар* бол түүний онцлогийг тодорхойлж байгаа шинжүүдийн нэгдмэл, харьцангуй тогтвортой нийлбэр байдаг. Чанарын тодорхой байдал бол хөгжлийн энэхүү зөрчилт шинжийг илэрхийлэхдээ юмс үзэгдлийн харьцангуй тогтвортой талыг нөхцөлдүүлж байдагт түүний онцлог оршино. Жишээ нь: олон улсын харилцаа бол олон янзын өөрчлөлтийн тасралтгүй үйл явц мөн, гэхдээ энэ өөрчлөлтийг түүний чанарын бүрдлийн тогтвортой талаас салгах аргагүй юм.

Чанар, *шинж* (symptom) хэмээх хоёр ухагдахуун явцуу утгаар авч үзвэл заримдаа нэгэн төрөл категорийн байдлаар хэрэглэгддэг. Гэхдээ, өргөн утгаар нь авч үзвэл энэ хоёр ухагдахууныг ялгах хэрэгтэй. Чанар юмс, үзэгдлийг бүхэлд нь хамран тодорхойлж байдаг бол, шинж нь тухайн юмс, үзэгдлийн аль нэг тал, хэсгийн тодорхойлолт болж байдаг ажээ. Нөгөө талд нийгэм хийгээд олон улсын харилцааны юмс, үзэгдэл олон чанартай байдаг. Юмс, үзэгдэл бүр бүхэлдээ чанарын нэг онцгой тодорхой тогтолцоо болж байдаг боловч уг юмс, үзэгдэл өөрийнхөө хүрээнд хэд хэдэн чанарын олонлиг болж байдаг. Энэ бол олон улсын харилцааны юмс үзэгдэл бүр олон янзын онцлог шинжүүдийн нийлбэр цогцыг өөртөө агуулж багтааж, янз бүрийн чанар болсон олон талыг агуулж байдгаас урган гарч байгаа юм. Олон улсын харилцаа бүхэл бүтэн систем мөний хамт бас олон тооны, янз бүрийн чанарыг агуулж байдаг. Юмс, үзэгдэл бүр бусадтай холбогдох, харилцан хамаарлын хувьд хичнээн баялаг байх тусмаа төчнөөн олон чанарыг илрүүлдэг.

Олон улсын харилцаа нь юмс үзэгдэл чанарын төдийгүй, бас *тооны* талтай. *Тоо* бол юмс, үзэгдэлд зуршмал байдаг нэгжүүд, тэдгээрийг бүрдүүлж буй хэсгүүдийн нийлбэр, юмсын хэмжигдэхүүн, хөгжлийн цар хэмжээ, түүний эрчмийн үе шатыг илэрхийлж буй тодорхой байдал мөн. Тоо бол тухайн чанарын идэвхжлийн үе шат, хэмжэгдэхүүн мөн. Чанар, тоо хоёр бол хоорондоо харилцан холбогдож, нэгдмэл болж байдаг. Чанар, тооны тодорхой байдлын нэгдэл *хэмлээ* (format) хэмээх ухагдахуунаар илэрдэг. Чухамхүү

хэмжээ л юмс үзэгдлийн чанар, тооны талуудын харилцан нөхцөлдсөн байдлыг харуулдаг.

Юмс, үзэгдэлд үеэ өнгөрөөж буй хуучин чанарын төлөв байдлын зэрэгцээгээр чанарын шинэ төлөв байдал үүсэж, энэ нь тооны тодорхой хуримтлалын дараагаар чанарын үндсэн өөрчлөлтөд ордог. Чингэхлээр *тооны өөрчлөлт* гэдэг бол шинэ чанарын тогтолцоо аажмаар хуримтлан бүрдэх үйл явц гэсэн үг билээ. Олон улсын амьдралд ч тооны өөрчлөлт чанарын үндсэн өөрчлөлтөд шилжих хуулийн дагуу хөгжин явагддагийг олон улсын харилцаа, дипломатын түүх батлан харуулдаг.

Өөр хоорондоо салшгүй холбогдож, харилцан үйлчилж байгаа олон улсын харилцааны тодорхой бүлэг юмс, үзэгдлийн дотоод, гол, дахин давтагдах шинж тэмдэг, үйл явцын цогцолбор нийлбэрийг *агуулга* гэнэ. *Хэлбэр* бол агуулга илэрч, хөгжиж, оршин тогтнох арга мөн. Хэлбэр агуулгатай салшгүй холбоотой, харилцан нөхцөлдсөн байдаг. Агуулга хэлбэрээ тодорхойлдог, хэлбэр үргэлж агуулгатай байдаг. Шинэ, хуучин агуулгын хоорондын зөрчилдөөн байнга тод илэрч байдаг. Тухайлбал, дээрх зөрчилдөөн 2007 оны 2 дугаар сард Мюнхенд болсон Аюулгүй байдлын бодлогын асуудлаарх бага хурал дээр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины хэлсэн үгнээс тодорхой харагддаг. Тэрбээр “ЗХУ таран бутарсан нь ХХ зууны геополитикийн хамгийн том сүйрэл болсон юм” гэж мэдэгдсэн юм. “ЗХУ-ыг дахин босгож ирвэл ХХI зууны хамгийн том сүйрэл болно” гэж Өрнөдийн улс төрчид, стратегийн шинжээчид хариуг нь барьсан юм. 2014 оны 10 дугаар сарын 24-нд Сочи хотноо *The World Order: New Rules or a Game without Rules* нэртэй зохиогдсон Олон улсын мэтгэлцээний Валдай клубын XI чуулганд В.Путины хэлсэн үгнээс ч дээрх санаа дахин тодорхой харагдаж байсан юм.

Мөн чанар гэдэг нь олон улсын харилцааны юмс үзэгдэл, үйл явцын шууд ажиглан мэдэх боломжгүй далд, шалтгаант холбоог тодорхойлдог, дотоод, харьцангуй тогтвортой талыг илэрхийлдэг. *Үзэгдэл* бол бодит байдлын юмс үзэгдэл, үйл явцын мөн чанарыг бодвол илүү тогтворгүй, шууд ажиглан мэдэж болохуйц, гадаад талыг авч үздэг. Мөн чанар, үзэгдэл хоорондоо салшгүй болохын хамт харилцан нэвтрэлцэж, шилжиж байдаг нь объектив бодит байдлын

талууд өөрчлөмтгий, хөдөлгөөнтэй байдгийг харуулж байгаа хэрэг.

Шалтгаан, үр дагаврын холбоо бол ерөнхий, түгээмэл хэлхээ холбоо илрэх нэг хэлбэр мөн. Тодорхой нөхцөлд өөр бусад үзэгдлийг зайлшгүй төрүүлдэг тийм үзэгдлийг **шалтгаан** хэмээх категори илэрхийлнэ. Шалтгаан хэмээн нэрлэгддэг бусад үйлчиллээр илрэх буюу өөрчлөгдөж буй үзэгдлийг **үр дагавар** хэмээх категори илэрхийлдэг. Шалтгаан, үр дагавар хоёрын хоорондын холбоо зүй тогтолт шинжтэй. Энэ бол тухайн шалтгаан зохих нөхцөлд хэзээ ямагт тодорхой үр дагавар гаргаж байдаг гэсэн үг ажгуу. Шалтгаан, үр дагаврын холбооны зүй тогтлыг танин мэдэх нь шинжлэх ухааны угтан харахуйн үндэс болдог. Олон улсын харилцаанд шалтгаангүй үзэгдэл байхгүй, бүх юмс үзэгдэл тодорхой нөхцлөөс хамаарна. Шалтгаант холбоо шинж чанараараа маш олон янз байдаг билээ. Тухайлбал, дотоод, гадаад холбоог ялган үзэх нь зүйн хэрэг юм. Дотоод шалтгаан бол нэг бүхэл бодит бүтцийн дотоод тал, хэсэг, хандлагуудын харилцан үйлчлэл мөн байхад, гадаад шалтгаан бол нэг материаллаг бүтэц нөгөөдөө үйлчлэх явдал юм. Олон улсын харилцааны аль нэг үзэгдлийг ойлгохын тулд юуны өмнө түүний дотоод шалтгааныг илрүүлэх нь чухал болой. Чухам тэр нь л үр дагавар илрэхэд шийдвэрлэх ач холбогдолтой байдаг.

Шалтгааныг бас гол, гол бус гэж хувааж болно. Гол шалтгаан үйл явцыг бүхэлд нь тодорхойлж, үзэгдлүүдийн уг мөн чанар нь болж байхад харин гол бус шалтгаан нь үйл явцын өрнөлтийг хурдасгах буюу удаашруулан, зөвхөн туслах чанарын учир холбогдолтой байдаг ажээ.

Шалтгааныг **шалтагтай** (casus billi) хутгаж үл болно. Шалтаг нь гарал үүслийн хувьд үр дагавартай холбогдолгүй. Тэр нь өөрөө үр дагавар төрүүлэхгүй, харин үр дагавар илрэх нэгэнт нөхцөлдсөн үйл явцыг зөвхөн «түргэтгэж» өгдөг. Шалтгаан, үр дагавар хоёр өөр хоорондоо байнгын харилцан үйлчлэлд оршдогт түүний диалектик мөн чанар оршино.

Зайлшгүй хэмээх категори бол дотоод, гол чухал холбоо, харилцаанаас зүй тогтол ёсоор урган гарч, урьдахь бүх хөгжлөөр нөхцөлдөн, үүний улмаас заавал гарч ирэх буюу зохих нөхцөлд гарах ёстой тэр л зүйлийг илэрхийлдэг. **Санамсаргүй** хэмээх нь тухайн үйл

явцын мөн чанараас, дотоод зүй тогтолт хөгжлөөс биш, харин түүний гадаад холбоо, харилцаанаас урган гарч байгаа үзэгдэл даруй мөн. Ямар нэгэн үйл явцын зайлшгүйг нээн илрүүлэх явдал нарийн, түвэгтэй ажилбар байдаг. Үүний тулд өөрийн онцгой өвөрмөц шинж чанар бүхий олон улсын харилцааны санамсаргүй үзэгдлүүдийг судлах, тэдгээрийг харьцуулж үзэх, тогтвортой, дахин давтагдагч нийтлэг талыг нь товойлгон гаргах, хөгжлийн хандлагыг тодорхойлох хэрэгтэй болно. Шинжлэх ухаан янз бүрийн санамсаргүйг судалснаар зайлшгүйг нээн илрүүлдэг. Санамсаргүйн цаана нуугдаж буй зайлшгүйг нээн илрүүлэх, үл хүсмээр санамсаргүйн үйлчиллийн хүрээг хязгаарлах нь шинжлэх ухааны зорилт мөн. Олон улсын харилцааны зүй тогтолт үйл явцыг танин мэдэх нь хүмүүст үл хүсмээр санамсаргүйн үйлчиллийг урьдчилан хориглох, эсвэл тэдгээр хуульзүйг хүн ардын тусын тулд ашиглах боломж олгодог. Ийнхүү санамсаргүй, зайлшгүйн харьцааны тухай диалектик ойлголт нь зөвхөн онолын төдийгүй, бас үйл ажиллагаанд ач холбогдолтой бөгөөд олон улсын харилцааг танин мэдэх, өөрчлөн байгуулах бүтээлч хэрэгсэл юм.

Бололцоо бол одоохондоо байхгүй боловч, үүсэж, хөгжиж чадах тэрхүү юмс үзэгдлийг тэмдэглэх категори юм. **Бодит байдал** бол нэгэнт буй болсон, оршин байж буй зүйл, энэ бол бодитой байж байгаа юмс, үзэгдлийн орчин ахуй билээ. Өөрөөр хэлбэл *бололцоо* гэдэг нь шинэ зүйл гарч ирэхийн урьдач нөхцөл, юмс үзэгдэл, үйл явцын хөгжил дэх хандлага, тухайлбал, объектив бодит байдлын дотор боловсорч, зохих нөхцөл бүрдсэн үед бодит байдал болон хувирах бүх юмс үзэгдэл мөн гэж үздэг. Хэрэгжиж биелсэн бололцоог бодит байдал хэмээнэ. Объектив бодит байдал цаг ямагт олон янзын чанартай байдаг, тиймээс түүнд олон янзын бололцоо агуулагдаж байдаг. Бололцоо бүхэн нь хөгжиж байгаа бодит байдлын дотор агуулагдсан эгшин юм. Хөгжлийн процесс бол бололцоо бодит байдал болж, тэр бодит байдал янз бүрийн шалтгааны улмаас шинэ шинэ бололцоог илрүүлж, энэ бололцоо нь зохих нөхцөл бүрдсэн үед хэрэгжиж бодит байдал болон хувирах замаар өрнөдөг. Зарим үед бодит бололцоо мэт харагддаг хоосон зүйлд хүмүүс объектив хуулийн үйлчиллийг харгалзахгүйгээр, түүнийг гүнзгий шинжлэн судлахгүйгээр, бодит байдлыг гаж тусгах үндсэн дээр зөгнөн зохиодог. Энэ бол бололцоогүйтэй адил болой.

Дээрхтэй холбоотой *магадлалын* (probability) категори гэж байдаг. Бололцоо, бодит байдлын харьцааны тоон илэрхийлэл *магадлалын* категориор илэрдэг. *Магадлалын* категори бол бололцооны үе шат, бололцоо бодит байдалд хэр зэрэг ойр байгааг харуулсан ухагдахуун даруй мөн. Аливаа бололцоо бодит байдалд хувирахад ямар нэг хэмжээний магадгүйг агуулж байдаг. Бололцоо тодорхой нөхцөлд бодит байдал болон хувирах магадлал хичнээн олон хувилбартай байх тусам чингэж хувирах явдлыг тооцоолох хэрэгтэй. Бололцоо бодит байдал болж хувирах магадлал нь тухайн бололцоо үзэгдэл, үйл явцын зүй тогтол, хөгжлийн хандлага, мөн чанартай холбоотой юу, эсвэл санамсаргүйтэй холбоотой юу гэдгээс тухайн үзэгдэл хөгжлийн ямар шатандаа буюу үүсэл, цэцэглэлт, төгсгөлийн шатандаа байна уу? гэдгээс хамаарна. Санмсаргүй олон арван үзэгдэл бодит байдалд хувирч болох магадлал нь статистик хуулинд захирагдаж, статистик аргаар хэмжигдэнэ. Бололцоо тодорхой байдал болж хувирах арга, шинж чанар, хурдцыг тухайн нөхцөл тодорхойлдог.

Бололцоо бодит байдалд хувирахад субъектив хүчин зүйлийн үүрэг онцгой ач холбогдолтой. Олон улсын харилцаанд бололцоо бодит байдал болохдоо тодорхой зорилго тавьсан хүмүүсийн ухамсартай бодлого, шийдвэр гаргах үйл явц, үйл ажиллагаагаар хэрэгждэг.

Бодит байдлыг шинжлэх ухааны үүднээс танин мэдэхэд *таамаглал* (hypothesis) чухал ач холбогдолтой. Таамаглал бол таамнасан мэдлэг мөн бөгөөд баримт, юмс үзэгдлийг ажиглаж, нэгтгэн дүгнэх явдал, бөөгнөрсөн боловч баттай нотлогдоогүй байгаа мэдлэгт үндэслэсэн магадгүй гэж санасан бодомж, урьдчилан тааварлал юм.

Энд шинжлэх ухааны танин мэдэхүйн арга, хэлбэрүүдийн тухай дурьдахгүй.

Олон улсын харилцааны ахисан түвшний судалгаа өөрийн онцлог талтай.

Үүнд: нэгд, *positive* буюу *descriptive analysis* нь өөрөөр хэлбэл үйл явцыг зураглан дүрсэлж, тэгж болно, тэгж ч болох юм, үгүй ч байж болно гэж авч үздэг; хоёрт, *normative* буюу *prescriptive analysis* нь өөрөөр хэлбэл хэм хэмжээ (погм) тогтоосон байдаг. Тийм байх,

тэгнэ, тиймээс тэгнэ. Өөрөөр хэлбэл судалгааны диспозитив (dispositif) буюу уян хатан, императив (jus cogens) imperativus буюу хатуу авч үзэх нь буй.

Шинэ чиг хандлага: Орчин үеийн аль ч шинжлэх ухааны салбарт судалгааны *математик аргын* ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдсээр байна. Орчин үеийн бүх шинжлэх ухааны танин мэдэхүй нь тайлбарлах аргаас нарийвчилсан математик аргыг улам бүр ашиглахад аажмаар шилжих замаар хөгжин урагшилж байгаа билээ. Бодит ертөнцийн юмс үзэгдэл, үйл явц тоо, чанарын тодорхой нэгдэлтэй байдаг нь бодит байдлыг танин мэдэх шинжлэх ухааны бүх салбарт математик аргыг зарчмын үүднээс хэрэглэхийг өөрийн объектив үндэс болгодог. Судалж буй зүйлийнхээ тоон өгөгдөл, харьцааг харгалзан үзэхгүйгээр бодит байдлын зүй тогтлыг жинхэнэ ёсоор бүрэн танин мэдэх бололцоогүй юм. *Шинжлэх ухаан математикийг хэрэглэдэг болсон үедээ л бүрэн төгс хөгжлийг олно хэмээн Иммануил Кант нотолсны учир энэ билээ.* Судалж байгаа зүйлсийн тоо, чанарын нэгдэл, хоорондын холбоо нь маш олон тооны хүчин зүйлсийг харгалзан үзэхийг шаарддаг. Энэ нь шинжлэх ухааны судалгаанд математик, кибернетикийг улам бүр өргөн хэрэглэхийг зайлшгүй болгож байна.

Cybernetike бол логик хийгээд математикт тулгуурлаж технологи, амьд организм, эдийн засаг-нийгэм, олон улсын харилцааны нарийн түвэгтэй динамик системийн зүй тогтолын мэдээллийг залж жолоодох ерөнхий зарчмыг судалдаг шинжлэх ухаан гэж тодорхойлж болно. Энэ динамик систем бүхэл мэдээллийг хүлээн авч, боловсруулж, хадгалах ба тогтоож, дамжуулж, залж удирдаж, бас эргэх холбооны зарчмаар үйлдэх чадвартай байдагт оршино. Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжил нь чухамхүү кибернетикийн шинжлэх ухааны ололтод суурилж байгаа билээ.

Олон улсын харилцааны ахисан түвшний судалгаанд *мэдлэгийн менежмент* (knowledge management) нэн чухал: Хуримтлагдсан мэдлэгийг зөв жолоодож, дахин хуваарилах үндсэн дээр шинэ мэдлэг буй болгох явдал судалгааны ажлын шинэлэг талыг илэрхийлнэ.

«Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: онол-түүх,

орчин үеийн зангилаа асуудлын иж бүрэн судалгаа» нь олон улсын харилцааны онолын сэтгэлгээ, геополитик судлал, улс төрийн шинжлэх ухаанд шинэ ухагдахууныг оруулж буй хэрэг юм. Үүгээрээ шинэ мэдлэгийг буй болгож, шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулж буй хэрэг гэж үзвээс зохилтой.

III. БРИКС, E7-гийн талаарх судалгааны үр дүн

Олон улсын харилцааны ахисан түшний судалгааны тодорхой загвар бол BRICS, E7 юм. Энд дээрх судалгааны категориудыг хэрэглэж болно. Эдүгээ олон улсын харилцаа олон туйл руу шилжиж, хүчний дахин хуваарилт эрчимтэй явагдаж байна. (Афганистаны Ерөнхийлөгч БНХАУ-аас, Египетийн Ерөнхийлөгч ОХУ-аас гадаад айлчлалаа эхлэсэн нь анхаарал татаж байна) Үүний тод жишээ нь дээр дурдсан БРИКС (Brazil, Russia, India, China and South Africa-BRICS) юм. Америкийн үндэстэн дамнасан олон улсын *consulting*, хөрөнгө оруулалтын “*Goldman Sachs Group*” 2001 онд хөгжингүй эдийн засагтай Их долоогийн бүлгийн орнудаас гадна дэлхийн эдийн засагт Бразил, ОХУ, Энэтхэг, Хятад (2011 онд ӨАБНУ нэгдсэн) үсрэнгүй хөгжиж буйг онцлон тэмдэглээд тэдгээр дөрвөн орны нэрийг хураангуйлан тийнхүү БРИКС гэж нэрлэжээ.

“*Goldman Sachs Group*”-ын судалгааны гол өгөгдөл, параметр нь ДНБ-ий PPP (Purchasing power parity) болон nominal (нэрлэсэн) үнэлгээ, демографийн өсөлт байв. БРИКС-ийн таван орон нь Их 20-ийн бүлэгт багтдаг бөгөөд 2014 оны 6 дугаар сарын байдлаар дурдсан таван орны ДНБ-ийн нийлбэр 30 их наяд, 744 тэрбум ам. доллар, хүн ам 3 тэрбум, валютын нөөц нь 4 их наяд ам. доллараар хэмжигдэж байна. Гэтэл ЕХ-ны ДНБ 18, 124 их наяд ам. доллар юм.

2014 оны 7 дугаар сард Бразилийн Форталеза хотод БРИКС-ийн дээд уулзалт зохион байгуулагдав. Энэхүү дээд уулзалт ОХУ Крымийн хойгийг өөртөө хүчлэн нэгтгэсний дараа, Энэтхэгт шинэ Засгийн газар байгуулагдаж Ерөнхий сайдаар сөрөг хүчний Нарендра Модри сонгогдож, Орос, Хятадын хийн хэлэлцээр байгуулагдаж, Бразилын шигшээ баг Дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд

ялагдсаны дараа болсноороо онцлог байв. Уулзалтын үеэр БРИКС-ын Хөгжлийн шинэ банк байгуулах Төгсгөлийн хэлэлцээрт гарын үсэг зурав.² Тус банк Шанъхайд байрлах бөгөөд дүрмийн санг өсгөж, 100 тэрбум ам. доллар байхаар тохиролцов. Судлаачдын үзэж буйгаар ирээдүйд энэ банк нь *Bretton Woods*-ийн институттэй өрсөлдөнө гэж үзэж байгаа ажээ.³

2012 оны 3 дугаар сараас Европын Холбооны (ЕХ) 7 дахь хөтөлбөрийн санхүүжүүлтээр «Трансатлантикийн харилцан ажиллагаа ба глобал засаглалыг төлөвшүүлэхэд түүний гүйцэтгэх үүрэг» сэдэвт ахисан түвшний судалгааны төслийг хэрэгжүүлж буй бөгөөд ЕХ, АНУ, Түркийн *think-tank* 13 академик институтийн “*Transworld*” консорциум түүнийг гүйцэтгэж байгаа ажээ. Төслийн хүрээнд “Олон улсын аюулгүй байдлын шинэ болон хувьслын чиг хандлага”⁴ сэдэвт хэлэлцүүлэг өрнүүлж байгаа юм. Аюулгүй байдал судлалын шинэ параметер нь: даяаршил, аюул судлал, хүний аюулгүй байдал болон аюулгүйжуулалтад төвлөрч байгаа ажээ. Чингээд эмпирик судалгааны түвшинд: *хоёрт*, БРИКС-ийн орнуудын эдийн засгийн сэргэн мандалт, түүний олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ, олон улсын харилцааны олон туйл глобал аюулгүй байдлын системийг тогтворгүй болгох магадлал өндөр болсоор байна гэсэн дүгнэлт хийсэн юм. Өрнөдийн стратеги судлаачдын үзэж буйгаар олон туйлт тогтолцоо олон улсын аюулгүй байдалд ноцтой занал учруулах болов гэж дүгнэж байгаа юм. Энэ бол нөлөөллийн болон эрсдлийн үнэлгээ юм.

Дээрх судалгааны онолын үндэс нь *Balance of Power* буюу “хүчний тэнцвэр”-т тулгуурласан *Rebalance Power* буюу хүчний дахин тэнцвэржүүлэх үзэл баримтлал юм.

“*Goldman Sachs Group*”-ын судалгааг гүнзгийрүүлэн үндэстэн

2. 2013 оны 3 дугаар сард Өмнөд Африкийн Дурбан хотноо зохион байгуулагдсан БРИКС-ийн 5 дахь дээд уулзалтаар 50 тэрбум ам. долларын дүрмийн сан бүхий хөгжлийн банк байгуулах асуудлаар санал нэгдсэн юм. 2013 оны 9 дүгээр сард Санкт-Петербургт зохиогдсон Их 20-ийн дээд уулзалтын үеэр БРИКС-ийн орнуудын удирдагчид хөгжлийн банк байгуулах хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.

3. 1999 онд Венесуэль улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Уго Чавес Бреттон Вүүдсийн институтц тухайлбан ОУВС-гаас бүрэн тусгаар бодлого явуула хэмээн зарлаж байсан боловч эдүгээ тус улсын эдийн засаг тун хүнд байдалд орж, инфляци 60 хувьд хүрчихээд байгаа юм.

4. Anne-Marie Le Gloannec, Bastien Irondelle and David Cadier. «New and Evolving Trends in International Security»-“The Transatlantic Relationship and the Future Global Governance” *Transworld*, Working Paper 13, April 2013, ISSN 2281-5252

дамнасан санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг consulting *Pricewaterhouse-Coopers* корпораци 2006 оны 10 дугаар сард гаргасан *Stern Review* илтгэлд долоон улс эдийн засгийн шинэ бүлэглэл *E7 (emerging 7 economies)* БНХАУ, Энэтхэг, Бразил, Мексик, ОХУ, Индонез Түрк)-г үүсгэж буйг тодорхойлсон юм. Судалгааны өгөгдөл, параметр нь аанай л ДНБ-ийн РРР болон нэрлэсэн үнэлгээ, демографийн өсөлт байв. 2050 он гэхэд тэдгээр улсын ДНБ дараах байдлаар өссөн байх ажээ. Үүнд:

БНХАУ: 70, 7 их наяд ам. доллар

Энэтхэг: 37, 6 их наяд ам. доллар

Бразил: 11, 3 их наяд ам. доллар

Мексик: 9, 3 их наяд ам. доллар

ОХУ: 8, 5 их наяд ам. доллар

Индонез: 7, 0 их наяд ам. доллар

Түрк: 3, 9 их наяд ам. доллар

гэхдээ дээрх орнууд өсөлтийн тодорхой хязгаарт тулж очно.

АНУ болон Өрнөдийн орнууд ДНБ-ийн тоон өсөлтөд анхаарал тавихаас гадна чанарын асуудал дээр онцгой анхаарч байгаа юм. Энд зөвхөн хоёр жишээ дурдахад: Европын цөмийн судалгааны байгууллагын (CERN) нүсэр том байгууламж болох Аварга Хадроны хурасгуурт эрчим хүчний асар том туршилт судалгаа хийгдэж байна. АНУ-ын Ливерморийн Үндэсний лабораторид (National Ignition Facility) 192 хүчирхэг хүчин чадал бүхий лазерын тусламжтай халуун цөмийн инерцийн урвал явуулснаар 500 тераваттын эрчим хүч гаргаж авах ажээ. 2006 онд дэлхийн нийт хүн ам 16 тераватт эрчим хүч хэрэглэсэн байна (The terawatt is equal to one trillion (10^{12}) watts).

IV. Судалгааны макро түвшин

Олон улсын харилцааны ахисан түвшний судалгаанд *макро* болон *микро* түвшний судалгаа чухал ач холбогдолтой. Шинэ Мянганы дараах олон улсын харилцаанд гарсан гол өөрчлөлтийн *макро түвшний гол дүгнэлт*:

Нэгд, 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист үйл ажиллагааны дараах глобал аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинээр авч үзэх болов.

Хоёрт. 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал: даяаршил хөгжлийн өргөн боломжоос гадна маш том эрсдлийг дагуулж буйг харуулав.

Гуравт. Арабын хавар, түүний үр дагавар нь лалын фундаменталист, экстремистүүд засгийн эрхэнд гарахыг санаархад хүргэж, үүнтэй холбоотой Исламын улс зэвсэгт бүлэг олон улсын аюулгүй байдалд заналхийлж эхлэв. Өөрөөр хэлбэл Өрнөдийн ардчилал арабын ертөнцөд тулж очоод газарт оров.

Дөрөвт. Афганистан, Иракийг тойрсон хурцадмал байдал, Хойд Солонгос, Ираны цөмийн хөтөлбөрийн заналхийлэл.

Тавд. Украины хямрал, түүнтэй холбоотой ОХУ-ын эсрэг Өрнөдийн эдийн засгийн хориг арга хэмжээ олон улсын харилцаанд шинэ хүйтэн дайны уур амьсгалыг оруулж байна гэж үзэхэд хүргэв. В.Путин Сочи хотноо зохиогдсон Валдайн олон улсын мэтгэлцээний клуб дээр хэлсэн үг тийм өнгө аястай байв.

Зургаад. олон улсын харилцаанд олон туйлт ертөнц бүрэлдэн буй болж байна. Энд ШХАБ, БРИКС-ийг тэмдэглэж байгааг дээр тэмдэглэсэн.

Монгол Улсын гадаад бодлогын параметрийг макро судалгааны түвшинд авч үзвэл:

Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм нь:

1. Үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, бие даасан (Mongolia's new foreign policy: National genuine interests, open, peaceful, multi-pillars, independence)
2. Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харьцах (Balanced partnership with her neighbors)
3. Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статус (Mongolia's international security and nuclear-weapon-free status);

4. Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого (Mongolia's «third neighbor» policy)
5. Монгол Улсын гурвалсан хөршийн бодлого (Mongolia's trilateral neighbors policy) эдгээр болно.

Дүгнэлт

Орчин үеийн шинжлэх ухаан бол мэдлэгийн олон салбарласан систем юм. Үүнтэй уялдан түүнд судалгааны олон талт аргазүй хэрэглэгдсээр байна. Аргазүй ийм олон янз байдаг нь бодит байдал өөрөө арвин баялаг бөгөөд янз бүрийн үзэгдэл, янз бүрийн хандлагыг шаардаж байгаатай холбоотой. Шинжлэх ухааны танин мэдэхүй гүнзгийрэх тусам шинжлэх ухаанд хэрэглэж буй аргуудын тоо улам өсч байна. Хэдийгээр арга олон боловч, тэдгээрийг хоёр хэсэгт хувааж болно. Хамгийн олон аргуудыг багтаасан эхний хэсэгт тодорхой шинжлэх ухааны буюу *тусгай арга* багтдаг. Цөөн тооны аргуудыг агуулсан бүлэгт шинжлэх ухааны *ерөнхий арга* багтдаг. Бүх шинжлэх ухаанд ямар нэг хэмжээгээр хэрэглэгддэгт түүний онцлог оршино. Шинжлэх ухааны ерөнхий аргуудын зарчим нь бодит байдлын нэлээд нийтлэг талыг тусгадаг учир илүү өргөн хүрээнд танин мэдэхүйн үйл явцыг зохицуулж байдаг. Тиймээс бид судалгааны аргазүйгээ улам боловсронгуй болгох шаардлагатай.

Эцэст нь, олон улсын харилцааны ахисан түвшний судалгаанд улс төрийн шинжлэх ухааны категориудыг ямагт харгалзан үзэж байх нь онол-аргазүйн зарчмын чухал ач холбогдолтой.

Ном зүй

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.2010
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ.: 2011
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. (Эрхэлсэн Д.Уламбаяр). УБ.: 2014
4. Burchill, Scott and Linklater, Andrew "Introduction" Theories of International Relations, ed. Scott Burchill. Palgrave.: 2005
5. Baylis, John, Steve Smith, and Patricia Owens. The Globalisation of World Politics, OUP, 4th edition. 2008
6. Models, Numbers, and Cases: Methods for Studying International Relations. Edited by Detlef F. Sprinz and Yael Wolinsky-Nahmias. The University of Michigan Press. Ann Arbor.: 2004
7. The Master of Advanced International Studies (M.A.I.S) Programme-2014-2015, Diplomatic Academy of Vienna
8. Anne-Marie Le Gloannec, Bastien Irondele and David Cadier. «New and Evolving Trends in International Security»-«The Transatlantic Relationship and the Future Global Governance» Transworld, Working Paper 13, April 2013, ISSN 2281-5252